



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 433

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 20,052,379.00 (хорин сая тавин хоёр мянга гурван зуун далан ес) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Зам, тээврийн хөгжлийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 10 дугаар сарын 19-ний
өдрийн 423 дугаар тогтоолын хавсралт

"ДБҮЭГ" ТӨҮГ-ын балансаас Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн
хөрөнгийн дансанд балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Марк	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Хөрөнгийн үнэ (төгрөгөөр)
1	Проектор	HD color projector	2	3,321,660.00	6,643,320.0
2	DVD Тоглуулагч	DVD player	2	120,000.00	240,000.0
3	Кабель -VGA-5 м	VGA cable5m	5	8,000.00	40,000.0
4	Зурагт	19" LCD	8	130,000.00	1,040,000.0
5	Хурлын HD камер	HD Videoconference Camera /Black	1	9,400,440.00	9,400,440.0
6	48 порт свич- S5700S-52P-LI-AC	48 port switcher	1	2,688,619.00	2,688,619.0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		19 (арван ес)		20,052,379.00 (хорин сая тавин хоёр мянга гурван зуун далан ес)

20,052,379.00